

Сүрьеэгийн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

Сорилын зөв хариулт

1-E, 2-B, 3-A, 4-A, 5-B, 6-A, 7-D, 8-E, 9-B, 10-D, 11-C, 12-A, 13-C, 14-D, 15-A, 16-A, 17-A, 18-B, 19-A, 20-B, 21-D, 22-D, 23-B, 24-E, 25-A, 26-B, 27-B, 28-C, 29-B, 30-D, 31-C, 32-A, 33-E, 34-C, 35-A, 36-A, 37-B, 38-C, 39-C, 40-E, 41-E, 42-A, 43-E, 44-D, 45-A, 46-A, 47-A, 48-C, 49-A, 50-C, 51-A, 52-A, 53-C, 54-D, 55-C, 56-E, 57-A, 58-B, 59-A, 60-E, 61-A, 62-C, 63-D, 64-B, 65-A, 66-C, 67-A, 68-A, 69-E, 70-C, 71-A, 72-E, 73-E, 74-C, 75-E, 76-C, 77-C, 78-A, 79-A, 80-C, 81-A, 82-A, 83-D, 84-B, 85-E, 86-B, 87-B, 88-B, 89-A, 90-E, 91-C, 92-B, 93-C, 94-A, 95-A, 96-B, 97-B, 98-A, 99-C, 100-B, 101-B, 102-B, 103-A, 104-E, 105-E, 106-A, 107-E, 108-A, 109-B, 110-C, 111-C, 112-B, 113-D, 114-A, 115-C, 116-B, 117-A, 118-B, 119-C, 120-C, 121-B, 122-A, 123-C, 124-A, 125-C, 126-D, 127-C, 128-B, 129-C, 130-C, 131-C, 132-A, 133-A, 134-C, 135-B, 136-B, 137-D, 138-B, 139-B, 140-B, 141-C, 142-C, 143-C, 144-B, 145-A, 146-E, 147-C, 148-C, 149-C, 150-C, 151-A, 152-A, 153-B, 154-B, 155-D, 156-A, 157-B, 158-D, 159-B, 160-C, 161-B, 162-E, 163-B, 164-B, 165-B, 166-A, 167-A, 168-B, 169-A, 170-C, 171-C, 172-C, 173-B, 174-B, 175-D, 176-A, 177-A, 178-A, 179-B, 180-A, 181-A, 182-D, 183-A, 184-C, 185-C, 186-A, 187-B, 188-A, 189-A, 190-A, 191-C, 192-A, 193-A, 194-C, 195-A,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Хөндийт сүрьеэгийн үед үүссэн хөндийн хэмжээ юунаас хамаарах вэ ?
 - A. Гэмтсэн эдийн хэмжээ, холбогч бронхийн байдал
 - B. Нянгийн хоруу чанар, хөндий үүсгэсэн сүрьеэгийн хэлбэр
 - C. Хөндийн хананы үхжил
 - D. Уушигны эдийн цусны эргэлтийн алдагдал
 - E. Бие махбодын эсэргүүцэл, нянгийн үржил
- /2./ Эмч хариуцсан өрхөөр явж цэрний сорьц цуглуулан сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг хэрэглэсэн бэ?
 - A. Идэвхитэй илрүүлэлт
 - B. Идэвхигүй илрүүлэлт
 - C. Хагас идэвхитэй илрүүлэлт
 - D. Идэвхигүй болон идэвхтэй илрүүлэлт
 - E. Хагас идэвхитэй болон идэвхгүй илрүүлэлт
- /3./ Эмчилгээ тасалсан тохиолдол гэж хэзээ тооцох вэ?
 - A. Сүрьеэгийн эмчилгээний явцад 2 сар түүнээс дээш хугацаагаар эмчилгээг орхих
 - B. Сүрьеэгийн эмчилгээний явцад шалтгаангүйгээр 14 хоног завсарлаад үргэлжлүүлэх
 - C. Сүрьеэгийн эмчилгээг 1 сарын хугацаагаар таслах
 - D. Сүрьеэгийн эмчилгээг 14 хоног таслаад эргэж ирэх

- Е. Дээрхи бүгд
- /4./ БЦЖ вакциныг хаана тарих вэ ?
- А. Арьсан дотор
 - В. Арьсан дор
 - С. Судсанд
 - Д. Арьсан дээр
 - Е. Булчинд
- /5./ Л-хэлбэрт шилжсэн сүрьеэгийн савханцар нь хэдэн цагийн дотор хөндлөн хуваагдаж үржих вэ?
- А. 10 цаг
 - В. Үржихгүй
 - С. 20-24 цаг
 - Д. Үржинэ
 - Е. 24-48 цаг
- /6./ Уушгины уг өөрчлөгдөх хам шинж сүрьеэгийн ямар хэлбэрийн үед илрэх вэ?
- А. Сүрьеэгийн бронхаденит
 - В. Захын тунгалгийн булчирхайн сүрьеэ
 - С. Голомтот сүрьеэ
 - Д. Хөндийт сүрьеэ
 - Е. Нэвчдэст сүрьеэ
- /7./ Сүрьеэгийн плеврит гэж юу вэ ?
- А. Цээжний гялтан хальсны үрэвсэл
 - В. Цээжний гялтан хальсны өвөрмөц үрэвсэл
 - С. Сүрьеэгийн нянгаар үүссэн хуурай ба шүүдэст цээжний гялтан хальсны өвөрмөц үрэвсэл
 - Д. Сүрьеэгийн нянгаар үүссэн цээжний гялтан хальсны үрэвсэл
 - Е. Дээрхи бүгд
- /8./ Ямар хэлбэрийн сүрьеэгээс туберкулем үүсдэг вэ?
- А. Голомтот
 - В. Нэвчдэст
 - С. Хөндийт
 - Д. Тархмал
 - Е. D-д зааснаас бусад хэлбэрүүдээс үүснэ.
- /9./ Доорхоос ямар тохиолдолд олон эмэнд дасалтай сүрьеэ гэж үзэх вэ?
- А. Изониазидад дасалтай
 - В. Изониазид+ рифампицинд дасалтай
 - С. Пиразинамид+ этамбутолд дасалтай
 - Д. Изониазид болон стрептомицинд дасалтай
 - Е. Дээрхи бүгд
- /10./ Хүүхдэд Мантугийн сорилын урвалыг дүгнэхэд эерэг гэсэн хариу урвал үүссэн бол ямар арга хэмжээ авах вэ?
- А. БЦЖ вакцин хийнэ
 - В. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ
 - С. Сүрьеэгийн эмчилгээ хийнэ.
 - Д. Бусад гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж сүрьеэгээр өвчилсөн эсэхийг тодруулна
 - Е. Дээрхи бүгд
- /11./ Сүрьеэгийн өвчлөлийг хэрхэн тодорхойлох вэ?
- А. Сүрьеэтэй тохиолдолын тоог 1000 хүн амд харьцуулж гаргана.
 - В. Тухайн жилдээ илэрсэн нийт сүрьеэтэй тохиолдлын тоогоор гаргана
 - С. Шинээр илэрсэн тохиолдлын тоог 100 000 хүн амд харьцуулж гаргана.
 - Д. Бүх сүрьеэтэй тохиолдлын тоог 10000 хүн амд харьцуулж гаргана.
 - Е. Дээрхи бүгд
- /12./ Төвийн гаралтай хорт хавдарыг ямар хэлбэрийн сүрьеэгээс ялган оношлох шаардлагатай вэ?
- А. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ

- В. Туберкулема
- С. Дугуй нэвчдэст сүрьеэ
- Д. Хөндийт сүрьеэ
- Е. Тархмал сүрьеэ

/13./ Сүрьеэгийн нян өсгөвөрлөх шинжилгээний хариу дунджаар хэд хоногийн дараа гарах вэ?

- А. 7 хоног
- В. 14 хоног
- С. 21-56 хоног
- Д. 2 хоног
- Е. Дээрхи бүгд

/14./ Сорвит хөндийт сүрьеэтэй өвчтөний уушгийг тогшиход илрэх өөрчлөлтийг тоочно уу?

А. Нэг болон 2 талын уушгины дээд дэлбэнд тогшилтын чимээ бүдгэрч, доод хэсгүүдэд хайрцагны чимээтэй

- В. Уушгины бүх талбайд тод авиатай
- С. Уушгины бүх талбайд хайрцагны чимээтэй
- Д. Гэмтсэн хэсэгт тимпаник чимээтэй ба бусад хэсэгт өөрчлөлтгүй
- Е. Дээрхи бүгд

/15./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?

- А. Уушигны цэр эерэг сүрьеэтэй өвчтөн
- В. Уушигны цэр сөрөг сүрьеэтэй өвчтөн
- С. Уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн
- Д. Уушигны сүрьеэ бусад эрхтэний сүрьеэтэй хавсарсан тохиолдол
- Е. Дээрхи бүгд

/16./ Витамин "В"-ийн солилцоог алдагдуулдаг сүрьеэгийн эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү?

- А. Изониазид
- В. Рифампицин
- С. Пиразинамид
- Д. Этамбутол
- Е. Стрептомицин

/17./ БЦЖ вакциныг зөв хийсэн тохиолдолд сорви үүсэх магадлал хэдэн хувь байдаг вэ?

- А. 90-95%
- В. 70-80%
- С. 60%
- Д. 50%
- Е. Дээрхи бүгд

/18./ Хүнд сүрьеэ өвчин голдуу үүсгэдэг сүрьеэгийн савханцарын төрлийг нэрлэнэ үү?

- А. Үхрийн төрлийн сүрьеэгийн савханцар
- В. Сүрьеэгийн савханцар
- С. Африкийн сүрьеэгийн савханцар
- Д. Бусад төрлийн сүрьеэгийн савханцар
- Е. Дээрхи бүгд

/19./ Туберкулин гэж юу вэ?

- А. Сүрьеэгийн нянгийн эндотоксин
- В. Сүрьеэгийн амьд нян
- С. Сүрьеэгийн үхсэн нян
- Д. Сүрьеэгийн нянгийн омгуудын холимог
- Е. Бод малын төрлийн сүрьеэгийн савханцар

/20./ Пиразинамидыг хэрэглэх үед гарч болох гаж нөлөөг нэрлэнэ үү?

- А. Хараа муудах
- В. Том үеэр өвдөх
- С. Сонсгол муудах
- Д. Захын мэдрэлийн үрэвсэл
- Е. Дээрхи бүгд

/21./ Холбогч эдийн түгээмэл өвчнүүдийн үед сүрьеэгээр өвчлөх магадлалыг нэмэгдүүлдэг гол шалтгааныг нэрлэнэ үү?

- A. Глюкокортикоид гормон удаан хэрэглэх
- B. Уг өвчний явц архаг байх
- C. Уургийн солилцоо алдагдсанаас
- D. Биеийн эсэргүүцэл суларсанаас
- E. Дээрхи бүгд

/22./ Сүрьеэгийн өвчлөл болон тархалтыг бууруулахад нөлөөлдөг гол урьдчилан сэргийлэх аргыг сонгоно уу?

- A. Сүрьеэтэй өвчтөнийг тусгаарлах
- B. БЦЖ вакцинжуулалт
- C. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
- D. Сүрьеэгийн халдварын эх уурхайг эрт илрүүлж, бүрэн төгс эмчлэх
- E. Урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийх

/23./ Уушигны голомтот сүрьеэгийн эмнэл зүйн явц голдуу ямар байдаг вэ?

- A. Шинж тэмдэг хурц тод илэрнэ
- B. Шинж тэмдэггүй буюу шинж тэмдэг бүдэг
- C. Ужиг явцтай
- D. Хүндрэлтэй
- E. Дээрхи бүгд

/24./ Сорвит хөндийт сүрьеэгийн үед гэмтсэн хэсэгт юу сонсогдохгүй вэ?

- A. Цөөн тооны жижиг нойтон хэржигнүүр
- B. Хуурай хэржигнүүр, гуурсан хоолойн амьсгал
- C. Янз бүрийн олон тооны хэржигнүүр
- D. Суларсан цулцангийн амьсгал
- E. Цулцангийн амьсгал

/25./ Сүрьеэгийн эмчилгээ хийлгээд эдгэрсэн тохиодол гэж хэн бэ?

A. Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэж, хяналтын сүүлийн 2 удаагийн цэрний шинжилгээнд сөрөг болж, эмнэл зүйн шинжүүд арилж, гэрлийн шинжилгээнд өөрчлөлт шимэгдсэн.

B. Шинэ уушгины түрхэц сөрөг өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэж, хяналтын 3 удаагийн цэрний шинжилгээнд сөрөг болж, биеийн байдал сайжран, гэрлийн шинжилгээнд өөрчлөлт шимэгдсэн

C. Шинэ уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн биеийн байдал сайжирч, эмчилгээг бүрэн дууссан

D. Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 дахь сарын түрхцийн шинжилгээнд эерэг болсон

- E. Дээрхи бүгд

/26./ Мантугийн сорилын хариу урвалыг хэдэн мм-ээс эхэлж халдварлагдсан гэж үзэх вэ?

- A. 12 мм
- B. 5-10 мм
- C. 2 мм
- D. 0 мм
- E. 17 мм

/27./ Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг бүртгэх маягыг нэрлэнэ үү?

- A. ТВ 05
- B. ТВ 15
- C. ТВ 01
- D. ТВ 03
- E. ТВ 06

/28./ Сүрьеэгийн анхдагч бүрдэл гэж юу вэ?

A. Уушгинд сүрьеэгийн гэмтэл үүсдэг анхдагч сүрьеэгийн хэлбэр юм

B. Уушгины эд үрэвсэж гэмтэхийн хамт угийн тунгалгийн булчирхай гэмтдэг хэлбэр.

C. Уушгинд анхдагч голомтот өөрчлөлттэй, тунгалгийн судасны болон угийн булчирхайн үрэвсэлтэй анхдагч сүрьеэгийн нэг хэлбэр юм.

D. Анхдагч сүрьеэгийн байршлаа олсон хэлбэр юм.

E. Дээрхи бүгд

/29./ Изониазидыг насанд хүрэгсдэд өдөр бүр хэрэглэх дундаж тунг бичнэ үү?

A. 15мг/кг

B. 5 мг/кг

C. 10 мг/кг

D. 20 мг/кг

E. 25 мг/кг

/30./ Хөндийт сүрьеэтэй өвчтөний цэрний түрхэцийн шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ ?

A. Сүрьеэгийн савханцар илэрнэ

B. Сүрьеэгийн савханцар огт илрэхгүй

C. Уян ширхэг илэрнэ

D. Зөв хариулт бол А ба С юм

E. Дээрхи бүгд

/31./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?

A. Түрхэц сөрөг уушгины сүрьеэтэй тохиолдол

B. Захын тунгалгийн булчирхайн сүрьеэтэй тохиолдол

C. Түрхэц эерэг уушгины сүрьеэтэй тохиолдол

D. Түрхэц эерэг болон сөрөг тохиолдлууд

E. Түрхэц сөрөг болон захын тунгалагийн булчирхайн сүрьеэтэй тохиолдол

/32./ Казеоз хатгалгааны үед цэрний түрхэцийн шинжилгээ голдуу ямар байх вэ ?

A. Эерэг байна

B. Сөрөг байна

C. Дээрхи бүгд

/33./ Сүрьеэгийн плевритийн оношлогоонд ач холбогдолтой шууд бус шинжүүдийг тоочно уу?

A. Уушгины гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн хуучин, үлдэц өөрчлөлт илрэх

B. Өвчний түүхэнд урьд нь сүрьеэгээр өвчилж байсан юмуу сүрьеэтэй өвчтөний хавьтал байх

C. Эмнэл зүйн шинжүүд болон бусад клиник шинжилгээнд өвөрмөц үрэвслийн шинж илрэх

D. Өргөн хүрээний антибиотик эмчилгээнд үр дүнгүй байх

E. Дээрхи бүгд

/34./ Уушгины цэр “эерэг” сүрьеэтэй нэг өвчтөн жилд дунджаар хэдэн хүнийг сүрьеэгийн нянгаар халдварлуулах эгзэгтэй вэ ?

A. 1- 10 хүн

B. 5-10 хүн

C. 15-20 хүн

D. 30 хүн

E. 100 хүн

/35./ Сүрьеэгийн эмчилгээний 2-р бүлгээр ямар тохиолдлуудыг эмчлэх вэ?

1. Дахилт

2. Тасалсан тохиолдол

3. Үр дүнгүй эмчлэгдсэн тохиолдол

4. Шинэ тохиолдол

5. Архаг тохиолдол

/36./ Уушгины гэрлийн шинжилгээнд уушигны ямар эмгэгийн үед цагираг сүүдрийн хам шинж илрэх вэ?

1. Гуурсан хоолойн гаралтай уулинхай

2. Хавдарын задрал

3. Хөндийт сүрьеэ

4. Уушгины голомтот сүрьеэ

5. Туберкулема

/37./ БЦЖ вакцины хэсэг газрын хүндрэлийг нэрлэнэ үү?

1. Хүйтэн буглаа
2. Ханиалгах
3. Захын тунгалгийн булчирхайн үрэвсэл
4. хөлрөх
5. Халуурах

/38./ Уушгины хурц милиар сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тодорхойлно уу?

1. Зөвхөн нэг талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан
2. Хоёр талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд тархсан
3. Жижиг болон дунд зэргийн хэмжээтэй голомтууд тодорхойлогдоно
4. Олон тооны шар будаа шиг жижиг голомтууд тодорхойлогдоно
5. Уушгинд “тамгалсан” хөндий үүссэн байна

/39./

Сүрьеэгийн сэжигтэй тохиолдолд зайлшгүй хийх оношлогооны шинжилгээг тоочно уу?

1. Цусны биохимийн шинжилгээ
2. Цэрний түрхэцийн шинжилгээ
3. Туберкулины сорил
4. Уушгины рентгенограмм
5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/40./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Цэртэй ханиах, цустай ханиах
2. Хордлогын хам шинж тод илрэх
3. Цэрний түрхэц эерэг гарах
4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч, СОЭ хурдсах
5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/41./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгүүдийг тоочно уу?

1. 21 хоногоос дээш хугацаанд ханиах
2. Цэр, цустай цэртэй ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурах, хөлрөх
5. Турах

/42./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн нэвчдэст хэлбэрийн үед эмнэл зүйд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Хордлогын хам шинж
2. Уушиг-гуурсан хоолой, гялтангийн хам шинж
3. Захын тунгалгийн булчирхайн өөрчлөлт
4. Хоол боловсруулах замын хямрал
5. Толгойн хүчтэй өвдөлт

/43./ Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 настай хүүхдэд Мантугийн сорил тавьж, 72 цагийн дараа хариуг шалгахад 6 мм хэмжээтэй гүвдрүү жижиг цэврүүний хамт үүссэн бол энэ урвалыг юу гэж дүгнэх вэ? Цаашид авах арга хэмжээг тодорхойлоно уу?

1. Эерэг урвал
2. Эмнэл зүйн шинжүүд болон бодит үзлэгийн өөрчлөлтийг шалгана
3. Цээжний гэрлийн шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно
4. Цусны ерөнхий шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно.
5. Эмнэл зүй болон бусад шинжилгээнд сүрьеэгүй нь батлагдсан бол химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.

/44./ Уушигны голомтот сүрьеэтэй шинэ тохиолдлыг эмчлэх эмчилгээний бүлэг, хугацааг сонгоно уу?

1. Нэгдүгээр бүлэг, 4 сар
2. Хоёрдугаар бүлэг, 8 сар

3. Хоёрдугаар бүлэг, 6 сар
 4. Гуравдугаар бүлэг, 6 сар
 5. Гуравдугаар бүлэг 4 сар
- /45./ Сүрьеэгийн бронхаденитыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү ?
1. Лимфийн хавдрууд (лимфогрануломатоз, лимфосаркома, лимфолейкоз)
 2. Төвийн гаралтай хорт хавдар
 3. Өвөрмөц бус лимфаденопати (корь, коклюш, вирусын халдварт өвчин г.м)
 4. Уушигны голомтот хатгалгаа
 5. Улаан хоолойн хавдар
- /46./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?
1. Шууд хяналттай эмчлэх
 2. Үр дүнгийн хяналт хийх
 3. Гаж урвалын хяналт хийх
 4. Биеийн жингийн хяналт
 5. Цусны ерөнхий шинжилгээ хийх
- /47./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү?
1. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал
 2. Туберкулины сорил 10 мм-ээс дээш эерэг урвалтай
 3. Бусад шинжилгээ болон эмнэл зүйд сүрьеэ үгүйсгэгдсэн
 4. Туберкулины сорилд эерэг гарсан бүх тохиолдол
 5. Гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн бага зэргийн өөрчлөлттэй
- /48./ Сүрьеэгийн нянг устгах ариутгалын уусмалыг нэрлэнэ үү?
1. Хлорамины уусмал
 2. 5% фенол
 3. Спирт
 4. 2% лизол
 5. Давсны хүчил
- /49./ Анхдагч сүрьеэгийн эмнэл зүйн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Сүрьеэгийн хордлого
 2. Сүрьеэгийн бронхаденит буюу цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
 3. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
 4. Нэвчдэст сүрьеэ
 5. Хөндийт сүрьеэ
- /50./ Уушигны бүтэц эвдрэлт сүрьеэгийн үндсэн шинжийг тоочно уу?
1. Гуурсан хоолойн тэлэлт
 2. Нянгийн ялгаруулалт
 3. Амьсгалын дутагдал
 4. Уушгины эдийн бүтэц эвдрэл
 5. Уушгины эдийн сорвижилт
- /51./ Уушигны голомтот сүрьеэгийн үед бодит үзлэгт ямар өөрчлөлтүүд илрэх вэ ?
1. Цээжний хэнхэрцэг өөрчлөлтгүй
 2. Тогшилтоор болон чагналтаар онц өөрчлөлтгүй
 3. Цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно
 4. Их хэмжээний хуурай нойтон хэржигнүүр сонсогдоно
 5. Цээжний хэнхэрцэг торх хэлбэртэй болсон байна
- /52./ Сүрьеэгийн хагас идэвхитэй илрүүлэлтэнд хамрагдах хүрээг тодорхойлно уу?
1. Сүрьеэтэй өвчтөний хавьтал
 2. Гэр оронгүй хүмүүс
 3. Хоригдол
 4. Оюутнууд
 5. Залуус
- /53./ Орчин үеийн сүрьеэгийн эмчилгээний зарчмыг сонгоно уу?
1. Эмчилгээг завсарлагаатай хийх
 2. Шууд хяналттай эмчлэх
 3. Нэг юмуу хоёр эмийг хосолж хэрэглэх

4. Богино хугацаагаар эмчлэх
 5. Урт хугацааны эмчилгээний горимыг сонгох
- /54./ БЦЖ вакцин хийх заалтыг нэрлэнэ үү?
1. Туберкулины сорилд эерэг хүүхэд
 2. Бага насны хүүхдэд
 3. Бүх насны хүүхдэд
 4. Гүйцэд, эрүүл нярай хүүхдэд
 5. Сүрьеэгээр өвчлөөгүй хүүхэд
- /55./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн хүндэрлийг тоочно уу?
1. Анхдагч хөндий
 2. Гуурсан хоолойн сүрьеэ
 3. Сорвит хөндийт сүрьеэ
 4. Ателектаз
 5. Нурууны ясны сүрьеэ
- /56./ Казеоз хатгалгааны үед илрэх үндсэн шинжийг бичнэ үү?
1. Хурц эхлэл
 2. Өндөр халуурах
 3. Цэртэй, цустай цэртэй ханиах
 4. Нойтон хэржигнүүр их хэмжээгээр сонсогдох
 5. Хуурай ханиах
- /57./ Сүрьеэгийн анхдагч бүрдэлийн бүрэлдхүүн хэсгүүдийг нэрлэнэ үү?
1. уушгины анхдагч голомт
 2. уушгины тунгалгийн судасны үрэвсэл
 3. уушгины угийн тунгалгийн булчирхайн үрэвсэл
 4. уушгины олширсон зураглал
 5. захын тунгалгийн булчирхайн үрэвсэл
- /58./ Мантугийн сорилын хариу урвалыг хүүхдэд хэдэн мм байвал эерэг урвал гэж тооцох вэ?
1. Гүвдрүү 10 мм
 2. Гүвдрүү 4 мм ба түүнээс доош хэмжээтэй
 3. Гүвдрүүний хэмжээ хамаарахгүйгээр үхжил, цэврүү үүсэх
 4. Гүвдрүү 2 мм хэмжээтэй
 5. Гүвдрүүгүй улайлт үүсэх
- /59./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн клиник-рентгены хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Бага хэлбэр
 2. Нэвчдэст хэлбэр
 3. “Хавдар” төст хэлбэр
 4. Шинж тэмдэггүй хэлбэр
 5. Хүндрэлтэй хэлбэр
- /60./ Сүрьеэгийн нянгийн эсрэг үйлчлэлтэй нэгдүгээр эгнээний эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?
1. Изониазид
 2. Рифампицин
 3. Пиразинамид
 4. Этамбутол
 5. Бүгд зөв
- /61./ Анхдагч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?
1. Бага насны хүүхэд өвчилнө
 2. Цусны их эргэлтээр тархах хандлагатай
 3. Тунгалгийг голдуу хамарч гэмтэнэ
 4. Зөвхөн уушгийг гэмтээнэ.
 5. Хурдан эдгэрнэ

/62./ Хүүхдийг сүрьеэгээс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн аргуудыг нэрлэнэ үү?

1. Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ
2. БЦЖ вакцинжуулалт
3. Дархлал дэмжих эмчилгээ
4. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
5. Урьдчилан сэргийлэх үзлэг

/63./ БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлалтай хүүхдэд илрэх туберкулины сорилын хариу урвалын онцлогийг тоочно уу?

1. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр ихэснэ
2. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр буурна
3. Хэт эерэг урвалтай буюу 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү үүснэ
4. Эерэг урвалтай буюу 10 мм-ээс доош хэмжээтэй гүвдрүү үүснэ
5. Улайлт гүвдрүүнээс том хэмжээтэй байна

/64./ Уушигны голомтот сүрьеэгийн хүндрэлүүдийг нэрлэнэ үү ?

1. Нэвчдэст сүрьеэ
2. Плеврит
3. Хөндийт сүрьеэ
4. Туберкулема
5. Сорвит голомтот сүрьеэ

/65./ Сүрьеэгийн эмчилгээний хоёрдугаар бүлгийн үргэлжлэх шатны эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэлүүдийг нэрлэнэ үү?

1. Изониазид
2. Рифамицин
3. Этамбутол
4. Стрептомицин
5. Пиразинамид

/66./ Хүүхдийн сүрьеэгийн оношлогоонд хэрэглэх гол шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. Цэрний шинжилгээ
2. Гэрлийн шинжилгээ
3. Томографийн шинжилгээ
4. Туберкулины сорил
5. Эдийн шинжилгээ

/67./ Уушигны голомтот сүрьеэгийн төгсгөлүүдийг нэрлэнэ үү?

1. Бүрэн шимэгдэнэ
2. Хатуурч шохойжсон голомт үүснэ
3. Задарч хөндийт сүрьеэ үүснэ
4. Уушгины бус эрхтэний сүрьеэ үүснэ
5. Гуурсан хоолойн сүрьеэ үүснэ

/68./ Элгэнд хортой гаж урвал үүсгэх боломжтой сүрьеэгийн эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?

1. Изониазид
2. Рифамицин
3. Пиразинамид
4. Этамбутол
5. Стрептомицин

/69./ Цэрний түрхэцийн шинжилгээний давуутай талуудыг тоочно уу?

1. Хялбар
2. Богино хугацаанд хариу гарна
3. Халдвартай хэлбэрийн сүрьеэг оношилно
4. Оношийг найдвартай батална.
5. Хямд өртөгтэй

/70./ Мантугийн сорилын хариу урвалыг хэдэн цагийн дараа хэмжиж тодорхойлох вэ ?

1. 24 цаг
2. 72 цаг
3. 12 цаг
4. 48 цаг
5. 2 цаг

/71./ Уушгины хоёрдогч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?

1. Голдуу насанд хүрэгсэд өвчилнө.
2. Цусаар тархахгүй, голдуу уушгийг голомтлог байдлаар гэмтэнэ
3. Задрах хандлагатай, эмчилгээ заавал шаардлагатай
4. Тунгалгийг хамарч гэмтээнэ.
5. Цусаар тархах хандлага өндөртэй

/72./ Эмэнд дасалтай сүрьеэ үүсэхээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл бол:

1. Сүрьеэг эрт илрүүлж, оношлох
2. Сүрьеэгийн эмчилгээг шууд хяналттай хийх
3. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг үр дүнтэй явуулах
4. Эмийн гаж нөлөөг хянаж, сэргийлэх
5. Сүрьеэгийн эмчилгээг ганцхан эмээр дагнаж хийхгүй, зөв хослуулах

/73./ Уушгины гэрлийн шинжилгээнд тархмал сүүдрийн хам шинж ямар өвчнүүдийн үед илэрч болох вэ?

1. Уушигны милиар сүрьеэ
2. Хорт хавдарын метастаз
3. Уушиг тоосжих өвчин
4. Зогсонгишлын уушиг
5. Уушгины жижиг голомтот хатгалгаа

/74./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн үед бодит үзлэгээр илрэх өөрчлөлтийг бичнэ үү?

1. Эгэмний дээд хэсэгт тогшилтын чимээ бүдгэрнэ
2. Далны хооронд тогшилтын чимээ бүдгэрнэ
3. Эгэмний дээд хэсэгт жижиг нойтон хэржигнүүртэй
4. Чагнахад онцын өөрчлөлтгүй
5. Тогшилтоор өөрчлөлтгүй

/75./ Уушгины сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг тоочно уу?

1. 14 хоногоос дээш хугацаагаар ханиах
2. Цэртэй, цустай ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурч, хөлрөх
5. Турах

/76./ Хүүхдийн анхдагч сүрьеэгийн оношлогоонд өргөн хэрэглэх шинжилгээний аргуудыг тоочно уу?

1. Цусанд уургийн хэмжээг тодорхойлох
2. Туберкулины сорил
3. Цэрний түрхэцийн шинжилгээ
4. Уушгины гэрлийн шинжилгээ
5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/77./ БЦЖ вакцин нь хүүхдийг ямар хэлбэрийн сүрьеэгээр өвчлөхөөс найдвартай хамгаалах вэ ?

1. Уушигны бус эрхтэний сүрьеэ
2. Хурц тархмал сүрьеэ
3. Уушигны сүрьеэ
4. Сүрьеэгийн менингит
5. Анхдагч сүрьеэ

/78./ Дэлбэнгийн нэвчдэст сүрьеэгийн (лобит) үед илрэх үндсэн шинжүүдийг тоочно уу?

1. Эмнэл зүйн шинж тод илэрсэн

2. Уушгийг тогшиход дэлбэн хамарсан тогшилтын чимээ бүдгэрсэн
 3. Цэрний түрхэц эерэг
 4. Эмнэл зүйн шинж тэмдэггүй
 5. Эмнэл зүйн шинж бүдэг илэрсэн
- /79./ Туберкулины сорилыг ямар зорилгоор хийх вэ?
1. Нөхөн вакцинжуулалтанд хамрагдах хүүхдийг сонгох
 2. Хүүхдэд сүрьеэгийн халдварыг эрт илрүүлэх
 3. Сүрьеэгийн халдварын жилийн эгзэгийг тодорхойлох
 4. Уушигны бус эрхтэний сүрьеэтэй тохиолдлыг оношлох
 5. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг хийх
- /80./ Аварга” хэмжээтэй цагираг сүүдэр гэж хэзээ тооцох вэ?
- A. 2 см
 - B. 2-4 см
 - C. 7 см түүнээс дээш
 - D. 7 см хүртэл
 - E. Дээрхи бүгд
- /81./ Туберкулем голдуу байрлах сегментийг нэрлэнэ үү?
- A. 1, 2, 6, 7
 - B. 3, 5, 8, 9
 - C. 1, 2, 6, 10
 - D. 8, 9, 10
 - E. Дээрхи бүгд
- /82./ Туберкулины сорилыг хаана хийх вэ?
- A. Арьсан дотор
 - B. Арьсан дор
 - C. Булчинд
 - D. Судсанд
 - E. Дээрхи бүгд
- /83./ Туберкулем голдуу хаанаас задардаг вэ ?
- A. Төвөөс
 - B. Захаас
 - C. Ирмэгээс
 - D. Зах ирмэгдүү, гадагшлуулагч бронх байгаа хэсгээс
 - E. Дээрхи бүгд
- /84./ Анхдагч сүрьеэгээр голдуу ямар насныхан өвчилдөг вэ?
- A. Өндөр настангууд
 - B. Бага насны болон өсвөр насны хүүхэд
 - C. Залуу насныхан
 - D. Идэр насныхан
 - E. Дээрхи бүгд
- /85./ Глюкокортикоид гормон удаан хугацаагаар хэрэглэсний улмаас сүрьеэ үүсдэг шалтгаан бол:
- A. Уг гормон Т эсийн идэвхийг бууруулна
 - B. Эсрэг биет үүсэх процессыг дарангуйлна
 - C. Махбодоос Са гадагшлуулалтыг нэмэгдүүлнэ
 - D. Фагоцитозын идэвхи дарангуйлна
 - E. Зөв хариулт бол: А, В, D, юм.
- /86./ Чихрийн шижин өвчинтэй 50 настай эмэгтэйд халуурах шинж гэнэт илэрсэн байна. Гэрлийн шинжилгээнд зүүн уушгины дээд дэлбэнд нэвчдэст өөрчлөлт тодорхойлогдсон бол цаашид оношийг тодруулахад ямар шинжилгээг заавал хийх ёстой вэ?
- A. Гуурсан хоолой дурандах
 - B. Сүрьеэгийн нян цэрэнд хайх
 - C. Амьсгалын багтаамж шалгах шинжилгээ
 - D. Цусны шинжилгээ
 - E. Туберкулины сорил

/87./

Сүрьеэгийн микобактерийг өсгөвөрлөхөд тохиромжтой хэмийг тэмдэглэнэ үү?

- A. 35 хэм
- B. 37 хэм
- C. 42 хэм
- D. -28 хэм
- E. 75 хэм

/88./ БЦЖ вакцин гэж юу вэ ?

- A. Сүрьеэгийн үхсэн савханцар
- B. Хоруу чанаргүй сүрьеэгийн амьд савханцар
- C. Сүрьеэгийн савханцарын хор
- D. Сүрьеэгийн савханцарын эд эсийн хэсэг
- E. Бүрэн бус антиген

/89./ Анхдагч сүрьеэгээс элбэг тохиолдох эмнэл зүйн хэлбэрийг нэрлэнэ үү?

- A. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
- B. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
- C. Сүрьеэгийн хордлого
- D. Уушигны голомтот сүрьеэ
- E. Дээрхи бүгд

/90./ Архаг архичин сүрьеэтэй тохиолдлын эмчилгээнд анхаарах зүйлсийг тоочно уу?

- A. Эмийг өдөр бүр харж уулгах
- B. Элэгний үйл ажиллагааг шинжилгээгээр хянах
- C. Эмнэлэгт хэвтүүлж эмчлэх
- D. В” төрлийн витамин уулгах
- E. Дээрхи бүгд

/91./ Төв мэдрэлийн системийн бусад эмгэг өвчнүүдээс сүрьеэгийн менингитийг ялган оношлоход хэрэглэдэг гол оношлогооны шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Захын цусны шинжилгээ
- B. Цусны биохимийн шинжилгээ
- C. Нугасны усны шинжилгээ
- D. Уушигны гэрлийн шинжилгээ
- E. Дээрхи бүгд

/92./ Сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх идэвхитэй илрүүлэлтэнд хэрэглэдэг гол шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Цэрний түрхэцийн шинжилгээ
- B. Цээжний гэрлийн шинжилгээ
- C. Туберкулины сорил
- D. Цусны шинжилгээ
- E. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/93./ “Б” дүүрэгт 2000 онд шинээр 40 түрхэц эерэг, 20 түрхэц сөрөг, 10 уушгины бус эрхтэний сүрьеэтэй тохиолдлууд бүртгэгдэн эмчлэгдээд 38 тохиолдол эдгэрсэн, 2 тасалсан, 1 үр дүнгүй эмчлэгдсэн ба бусад нь эмчилгээ дууссан гэсэн бол уг дүүргийн эдгэрэлтийн түвшинг бодож сонгоно уу?

- A. 85%
- B. 100%
- C. 95%
- D. 50%
- E. 75%

/94./ Уушгинд үүссэн хөндийг илрүүлэхийн тулд нэмэлт зайлшгүй хийгдэх шинжилгээг нэрлэнэ үү?

- A. Цээжний эгц зураг авах
- B. Цээжний хажуу зураг авах
- C. Эгц байдлаар томограф хийх
- D. Хажуугаас томограф хийх

Е. Зөв хариулт бол: с ба d юм.

/95./ Сүрьеэгийн эмчилгээний 1-р бүлгийн хяналтын түрхэцийн шинжилгээг хэд хэдэн сард хийх ёстой вэ ?

- A. 2, 5, 6 сард
- B. 3, 5, 8 сард
- C. 2, 5, 7 сард
- D. 5, 6 сард
- E. Дээрхи бүгд

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь A, B, C, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
- 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
- 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

- Зөв, Зөв, Зөв (A.)
- Зөв, Зөв, Буруу (B.)
- Зөв, Буруу, Буруу (C.)
- Буруу, Зөв, Буруу (D.)
- Буруу, Буруу, Буруу (E.)

/96./ Манай оронд хэрэглэдэг туберкулины сорилын төрлийг нэрлэнэ үү?

- A. ХЭФ-ийн сорил
- B. Мантугийн сорил
- C. Пиркегийн сорил
- D. Кохын сорил
- E. дээрхи бүгд

/97./ Эмчлүүлэгчдэд хамгийн үр дүнтэй горимыг нэрлэнэ үү?

- A. Эмпирик
- B. Индивидуаль
- C. Стандарт

/98./ Мантугийн сорил тавихад хэрэглэгдэх туберкулины нэгж тунг сонгоно уу?

- A. 2 ТН
- B. 5ТН
- C. 1ТН
- D. 20 тн

/99./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээг ямар эмээр хийдэг вэ?

- A. стрептомицин
- B. рифампицин
- C. изониазид
- D. этамбутол
- E. дээрхи бүгд

/100./ Нэвчдэст сүрьеэг найдвартай оношлох аргыг нь сонгоно уу?

- A. гэрлийн шинжилгээ
- B. цэрний шинжилгээ
- C. цусны шинжилгээ

- D. гуурсан хоолой дурандах шинжилгээ
E. томографийн шинжилгээ
- /101./ ОЭДС-гийн эмчилгээ тасалсан тохиолдол гэж?
A. курс эмчилгээний хугацаанд 1 сар ба түүнээс дээш хугацаагаар эмчилгээ тасалсан
B. курс эмчилгээний хугацаанд 2 сар ба түүнээс дээш хугацаагаар эмчилгээ тасалсан тохиолдлыг
C. Курс эмчилгээний хугацаанд 3 сар ба түүнээс дээш хугацаагаар эмчилгээ тасалсан тохиолдлыг
- /102./ Сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлал тогтвортой юу?
A. тогтвортой, насан туршид хадгалагдана
B. тогтворгүй, дунджаар 6-7 жил хадгалагдана
C. тогтворгүй 15 жил хадгалагдана
- /103./ Уушигны гэрлийн шинжилгээнд илрэх тархмал сүүдрийн хам шинж гэж юу вэ?
A. Уушигны 2-оос дээш сегментийг хамарсан олон тооны голомтот сүүдэр илрэх
B. Уушигны нэг дэлбэнг хамарсан сүүдэржилт
C. Уушигны 1-2 сегмент хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй гану нэг юмуу олон тооны сүүдэр илрэх
D. Уушгинд цагираг сүүдэр илрэх
E. уушигны талбайд 12 мм-ээс дээш хэмжээтэй дугуй сүүдэр илрэх
- /104./ Соривт хөндийт сүрьеэгийн үед гэмтсэн хэсэгт юу сонсогдохгүй вэ?
A. цөөн тооны жижиг нойтон хэржигнүүр
B. хуурай хэржигнүүр, гуурсан хоолойн амьсгал
C. янз бүрийн олон тооны хэржигнүүр
D. суларсан цулцангийн амьсгал
E. цулцангийн амьсгал
- /105./ Элэгний хүнд хэлбэрийн эмгэгтэй өвчтөнд аль эмийг хэрэглэхгүй вэ?
A. Этионамид
B. Циклосерин
C. Канамицин
D. Офлаксоцин
E. Пиразинамид
- /106./ Уушигны сүрьеэгийн үед эмгэг өөрчлөлт ихэнхдээ хэддүгээр сегментэд байрладаг вэ?
A. 1, 6 ба 2
B. 8, 9 ба 10
C. 1-10 сегмент
- /107./ Ямар хэлбэрийн сүрьеэгээс соривт хөндийт сүрьеэ бараг үүсэхгүй вэ?
A. голомтот сүрьеэ
B. нэвчдэст сүрьеэ
C. туберкулём
D. тархмал сүрьеэ
E. гуурсан хоолойн сүрьеэ
- /108./ Идэвхитэй илрүүлэлт гэж юу вэ?
A. бүх хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэг илрүүлэх
B. сүрьеэгээр өвчлөх эгзэг өндөртэй хүмүүсийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийж илрүүлэх
C. эмчид хандсан тохиолдлуудаас сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг сонгож , шинжилгээ хийн илрүүлэх
- /109./ БЦЖ вакцины дараа үүссэн сорви ямар хэмжээтэй байвал үр дүнтэй дархлал тогтсон гэж үзэх вэ?
A. 2 мм
B. 4-6 мм
C. 11 мм
D. 1 мм
E. дээрхи бүгд

/110./ "Аварга" хэмжээтэй цагираг сүүдэр гэж хэзээ хэлэх вэ?

- A. 2 см
- B. 2-4 см
- C. 7 см түүнээс дээш
- D. 7 см хүртэл
- E. дээрхи бүгд

/111./ Сүрьеэгийн савханцар ямар хэлбэрт шилжиж болох вэ?

- A. риккетсии
- B. вирус
- C. L-хэлбэр ба шүүгдэгч хэлбэр
- D. дээрхи бүгд

/112./ Өвчтөний хожимдол гэж хэзээ тооцох вэ?

- A. 14 хоног ханиалгаад эмчид хандсан
- B. 45 хоног ханиалгаад эмчид хандсан
- C. 7 хоног ханиалгаад эмчид хандсан

/113./ Уушигны туберкулемыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү?

- A. захын хорт хавдар
- B. Дүүрэн киста
- C. Дугуй нэвчдэст сүрьеэ
- D. Хоргүй хавдар
- E. дээрхи бүгд

/114./ ОЭДС-гийн эрчимт шатанд цэрний хяналтын шинжилгээг хэдэн сарын зайтай авдаг вэ?

- A. 1 сар
- B. 2 сар
- C. 3 сар

/115./ Өрхийн эмч сүрьеэтэй тохиолдлын хавьтлыг шинжлэн хүүхдийн сүрьеэг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг ашигласан бэ?

- A. идэвхитэй
- B. идэвхигүй
- C. хагас идэвхитэй

/116./ Хүүхдэд Мантугийн сорилын хариу урвалд цэврүү, үхжил үүссэн байвал ямар урвалд тооцдог вэ?

- A. хэт эерэг
- B. хэт өндөр эерэг
- C. эерэг
- D. эргэлзээтэй
- E. сөрөг

/117./ Казеоз хатгалгааны үед цэрний түрхэцийн шинжилгээ голдуу ямар байх вэ?

- A. ихэнхдээ эерэг байна
- B. сөрөг байна
- C. аль аль нь байж болно
- D. аль нь ч биш

/118./ Туберкулины сорилд эерэг урвал өгвөл юу гэж дүгнэх вэ?

- A. сүрьеэгээр өвчилсөн
- B. сүрьеэгийн нянгаар халдварлагдсан
- C. сүрьеэгийн халдвар аваагүй

/119./ ОЭДС-гийн халдваргүй болсон гэж аль тохиолдлыг хэлэх вэ?

- A. цэрний түрхэцийн шинжилгээгээр халдвар ялгаруулахгүй болсон
- B. өсгөвөр болон түрхэцийн нэг удаагийн шинжилгээгээр халдвар ялгаруулахгүй болсон.
- C. өсгөврийн шинжилгээгээр дараалан 2 удаа сөрөг болсон

- /120./ Сүрьеэгийн нянгаар халварлагдсаныг тодорхойлох шинжилгээний аргыг нэрлэнэ үү?
- A. цэрний шинжилгээ
 - B. гэрлийн шинжилгээ
 - C. туберкулины сорил
 - D. цусны шинжилгээ
 - E. дээрхи бүгд
- /121./ Идэвхитэй илрүүлэлтийн үед хэрэглэдэг гол шинжилгээний аргыг нэрлэнэ үү?
- A. цэрний түрхэцийн шинжилгээ
 - B. цээжний гэрлийн шинжилгээ
 - C. туберкулины сорил
- /122./ Уушигны гэрлийн шинжилгээнд илрэх эмгэг сүүдрийн тодрол юуг заадаг вэ?
- A. өөрчлөлтийн идэвхийг
 - B. өөрчлөлтийн бүтэцийг
 - C. өөрчлөлтийн шалтгааныг
- /123./ Маш олон эмэнд дасалтай сүрьеэ гэж юу вэ?
- A. изониазид, рифампицины хослолоос бусад эмэнд дасалтай тохиолдлыг
 - B. дор хаяж изониазид, рифампицины хослолд дасалтай тохиолдлыг
 - C. Сүрьеэгийн 2-р эгнээний 2-оос дээш төрлийн эмэнд дасалтай тохиолдлыг
- /124./ БЦЖ вакциныг зөв хийсэн тохиолдолд хэдэн хувьд нь сорви үүсэх магадлалтай вэ?
- A. 90- 95%
 - B. 70-80 %
 - C. 60%
 - D. 50%
- /125./ Уушигны нэвчдэст сүрьеэ задрах хандлага ихтэй байдаг шалтгааныг тайлбарлана уу?
- A. хүний бие махбодь сүрьеэгийн нянд хэт өндөр мэдрэг байх
 - B. сүрьеэгийн нянгийн эсрэгтөрөгч чанарын улмаас уушигны эд хэт цочирсон байх
 - C. үрэвслийн голомтонд сүрьеэгийн нян маш их хэмжээгээр үржиж олширсон байх
- /126./ Сүрьеэгийн менингитийн үед эрт илрэх шинж тэмдэг юу вэ?
- A. сонсгол муудах
 - B. Хараа муудах
 - C. шөрмөсний рефлексүүд ихсэх
 - D. Дагзны булчингийн хөшилт үүсэх
- /127./ Цэрний өсгөвөрлөх шинжилгээнд дунджаар хэд хоноод сүрьеэгийн нян ургах вэ?
- A. 7 хоног
 - B. 14 хоног
 - C. 21-30 хоног
 - D. 3 хоног
 - E. 45 хоног
- /128./ Сүрьеэгийн анхдагч бүрдэлтэй голдуу ялган оношлогддог өвчин бол:
- A. уушигны угийн тунгалагийн булчирхайд цацагдсан хорт хавдар
 - B. уушигны хурц хатгалгаа
 - C. уушигны гаж хөгжил
 - D. эозинофилийн нэвчдэс
- /129./ Цэрний түрхэцийн шинжилгээний хариунд /+++/ гэсэн байвал 300 харах талбайд хэдэн ширхэг ХТН илэрсэн гэж үзэх вэ?
- A. 1-2 ХТН 300 ХТ
 - B. 10-299 ХТН 300 ХТ
 - C. 300-ААС дээш ХТН 300 ХТ
- /130./ ОЭДС-тэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай ЭМС-ын хэдэн тоот тушаал байдаг вэ?
- A. 190
 - B. 85

C. 176

/131./ Хүүхдэд Мантугийн сорилын хариу урвал хэдэн мм байвал эерэг гэж тооцох вэ?

A. 3-4 мм

B. 5-11 мм

C. 12-16 мм

/132./ Ямар хэмжээтэй голомтот сүүдрийг милиар гэж нэрлэдэг вэ?

A. 1-2 мм

B. 3-4 мм

C. 5-8 мм

D. 9-12 мм

E. дээрхи бүгд

/133./ ХДХВ-ийн халдвартай ОЭДС-тэй өвчтөний эмчилгээнд эсрэг заалттай эмийг нэрлэнэ үү

A. Тиацетазон

B. Офлаксоцин

C. Канамицин

D. Пиразинамид

/134./ Сүрьеэгийн анхдагч бүрдэл гэдэг нь:

A. уушгинд сүрьеэгийн гэмтэл үүсдэг анхдагч сүрьеэгийн хэлбэр

B. уушигны эд үрэвсэж гэмтэхийн сацуу угийн тунгалагийн булчирхай гэмтдэг хэлбэр

C. уушгинд голомтот болон нэвчдэст өөрчлөлт бүхий лимфангит, угийн булчирхайн үрэвсэлтэй анхдагч сүрьеэгийн хэлбэр

/135./ ОЭДС-тэй өвчтний хавьтлууд ямар хугацаагаар сүрьеэгийн диспансерийн хяналтанд байх шаардлагатай вэ?

A. 2 жил

B. 5 жил

C. 10 жил

/136./ Мантугийн сорилын хариу урвалд хэдэн мм-ээс эхэлж халдварлагдсан гэж үзэх вэ?

A. 12 мм

B. 5 мм

C. 2 мм

D.

0 мм

E. 17 мм

/137./ Захын тунгалагийг булчирхайн сүрьеэг ялган оношлох өвчнүүдийг нэрлэнэ үү?

A. тунгалагийн булчирхайн хавдарууд

B. өвөрмөц бус лимфаденит

C. Саркоидозын үеийн тунгалагийн булчирхайн гэмтэл

D. дээрхи бүгд

/138./ БЦЖ вакциныг хэдэн хэмд хадгалах ёстой вэ?

A. 0 + 4 хэм

B. 0 + 8 хэм

C. 0-ээс доош хэмд

/139./ ОЭДС-гийн эмчилгээний үр дүнгүй тохиолдол гэж ?

A. Сүүлийн 5 удаагийн өсгөвөр дараалан сөрөг гараагүй тохиолдлыг

B. Сүүлийн 3 удаагийн өсгөвөр дараалан сөрөг гараагүй тохиолдлыг

C. Сүүлийн 1 удаагийн өсгөвөр дараалан сөрөг гараагүй тохиолдлыг

/140./ Таталтын гаж нөлөө илэрдэг сүрьеэгийн эмийг нэрлэнэ үү?

A. Этионамид

B. Циклосерин

C. Канамицин

D. Офлаксоцин

- Е. Пиразинамид
- /141./ Цэрийг шинжилгээнд 3 удаа цуглуулж шинжилснээр хэдэн хувийн оношлох магадлалтай вэ?
- A. 50%
 - B. 75%
 - C. 85%
 - D. 90%
 - E. 100%
- /142./ Соривт хөндийт сүрьеэгийн үед цусны ерөнхий шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
- A. онцын өөрчлөлтгүй
 - B. цус багадалтын шинж , уагаан цогцосын тоо бага зэрэг олширсон
 - C. цагаан цогцосын тоо бага зэрэг олширсон, лимфоцит цөөрсөн , СОЭ өндөр, гипохром анемитай
 - D. цагаан цогцосын тоо хэт олширч, лейкограмм зүүн тийш хазайсан
- /143./ Сүрьеэгийн хордлогын үед гэрлийн шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ?
- A. голомтот сүүдрүүд
 - B. уушигны уг өргөсөж өөрчлөгдөнө.
 - C. өөрчлөлт илрэхгүй
 - D. хязгаарлагдсан нэвчилт сүүдэр
 - E. тархмал сүүдэр
- /144./ Олон эмэнд дасалтай сүрьеэ гэж юу вэ?
- A. Изониазид рифампицины хослолоос бусад эмэнд дасалтай тохиолдлыг хэлнэ.
 - B. Дор хаяж изониазид рифампицины хослолд дасалтай тохиолдлыг хэлнэ
 - C. Изониазид , этамбутол, стрептомицинд дасалтай тохиолдлыг хэлнэ
- /145./ БЦЖ вакциныг хаана тарих вэ?
- A. арьсан дотор
 - B. арьсан дор
 - C. судсанд
 - D. арьсан дээр зурах
 - E. булчинд
- /146./ Нян гуурсан хоолойгоор дамжин тархаж үүссэн сүрьеэгийн үед голомтот өөрчлөлт голдуу уушигны аль хэсэгт байрлах вэ?
- A. дээд дэлбэнд
 - B. доод ба дунд дэлбэнгүүдэд
 - C. урд талын сегментүүдийг хамарч
 - D. ар талын сегментүүдийг хамарч
 - E. б ба в-д заасан байрлалд
- /147./ Сүрьеэгийн өвчлөл гэдэг нь:
- A. сүрьеэтэй тохиолдлын тоог 1000 хүн амд харьцуулж гаргасан тоо.
 - B. тухайн жилдээ илэрсэн нийт тохиолдлын тоо
 - C. шинээр илэрсэн тохиолдлын тоог 100 000 хүн амд харьцуулж гаргасан тоо
- /148./ Уушигны тархмал сүрьеэ гэж юу вэ?
- A. сүрьеэгийн нян цусаар тархаж үүсгэсэн гэмтэл
 - B. хоёр уушгинд нилэнхүйдээ тархсан өөрчлөлт
 - C. сүрьеэгийн нян цус, тунгалагийн шингэн, гуурсан хоолойгоор дамжин тархаж уушигны завсарын эдийн өөрчлөлт болон голомтот гэмтэлийг ихэнхдээ 2 талын уушгинд үүсгэнэ.
- /149./ Цэрний түрхэцийг ямар хэмжээтэй бэлддэг вэ?
- A. 1x2 см
 - B. 3x2 см
 - C. 2x3 см
 - D. 3x3
- /150./ Дугуй нэвчдэст сүрьеэтэй зайлшгүй ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү?
- A. уушигны хатгалгаа

- В. уушигны бэтэг
- С. уушигны хорт хавдар
- D. эозинофилийн нэвчдэс
- Е. буглаа

/151./ Эмийн анхдагч дасалд аль нь хамаарагдах вэ?

А. сүрьеэгийн эмчилгээ урьд нь огт хийлгэж байгаагүй буюу нэг сараас доош хугацаагаар хийлгэсэн

В. сүрьеэтэй өвчтний хавьтлыг хэлнэ

С. сүрьеэгийн 1-р бүлгээр эмчилгээ хийлгэсэн өвчтөнд илрэхийг хэлнэ

/152./ Уушигны уг өөрчлөгдөх хам шинж сүрьеэгийн ямар хэлбэрийн үед илрэх вэ?

А. сүрьеэгийн бронхаденит

В. захын тунгалагийн булчирхайн сүрьеэ

С. голомтот сүрьеэ

D. хөндийт сүрьеэ

Е. нэвчдэст сүрьеэ

/153./ Анхдагч сүрьеэгийн үед илэрч болох параспект урвалын шалтгааныг тайлбарлана уу?

А. сүрьеэгийн савханцар бүх салстанд үрэвсэл үүсгэнэ

В. сүрьеэгийн нянгийн хоронд бүх салст цочирч харшлын урвал явагдана.

С. дээрхи бүгд

/154./ Сүрьеэгийн илрүүлэлтийн аргаас хямд бөгөөд илрүүлэх магадлал өндөртэй аргыг нэрлэнэ үү?

А. идэвхитэй илрүүлэлт

В. идэвхигүй илрүүлэлт

С. хагас идэвхитэй илрүүлэлт

/155./ Бага насны хүүхэд сүрьеэгийн менингитээр өвчлөхөд шууд нөлөөлдөг шалтгааныг нэрлэнэ үү?

А. Бие махбодын хэт мэдрэмтгий байдал

В. судасны ханын нэвчимхий чанар ихэссэнтэй холбоотой

С. мэдрэлийн системийн хөгжил сул доройгоос

D. биеийн ерөнхий болон БЦЖ вакцины дараахь дархлал сул буюу үүсээгүйтэй холбоотой

/156./ Уушигны цус алдалт гэж хэзээ тооцох вэ?

А. ханиахад юмуу тайван үед амьсгалын замаас их хэмжээгээр цус гарах

В. амьсгалын замаас цустай шүлс юмуу, цусны хольцтой цэр гарах

С. ханиах үед саадтай ховхордог нөжирсөн цус

/157./ 45 кг жинтэй хүнд аминогликозидын антибиотeкийн хэрэглэх тун хэд вэ?

А. 0,5 гр

В. 0,75 гр

С. 1,0 гр

/158./ Мантугийн сорил хэт өндөр эерэг урвалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?

А. БЦЖ вакцинжуулна.

В. урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ

С. сүрьеэгийн эмчилгээнд шууд оруулна

D. сүрьеэгийн бусад гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж онош тодруулна

Е. ажиглаж хяналтанд байлгана

/159./ Сүрьеэгийн микобактерийг өсгөвөрлөхөд тохиромжтой хэмийг тэмдэглэнэ үү?

А. 35 хэм

В. 37 хэм

С. 42 хэм

D. 40 хэм

/160./ Цэрний түрхэц сөрөг уушигны сүрьеэгийн тохиолдол гэж юу вэ?

А. нэг удаагийн цэрэнд түрхэц эерэг ба бусдад нь түрхэц сөрөг бол

В. 2-оос дээш удаагийн цэрэнд түрхэц эерэг гарсан бол

С. 2-оос дээш удаагийн цэрэнд түрхэц сөрөг ч өсгөвөрлөх шинжилгээнд эерэг гарсан бол

/161./ БЦЖ вакцин гэж вu вэ?

- A. сүрьеэгийн үхсэн савханцар
- B. хоруу чанаргүй сүрьеэгийн амьд савханцар
- C. сүрьеэгийн савханцарын эндотоксин
- D. сүрьеэгийн савханцарын эсийн хэсэг
- E. бүрэн бус антиген

/162./ Уушигны гэрлийн шинжилгээнд илрэх голомтот сүүдрийн хам шинж гэж юуг хэлэх вэ?

- A. уушигны талбайд 12 мм-ээс дээш хэмжээтэй дугуй сүүдэр илрэх
- B. уушигны нэг дэлбэнг хамарсан сүүдэржилт
- C. уушигны аль нэг хэсэгт агаартай хөндий үүсэх
- D. уушигны талбайг нэлэнхүйд нь хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй сүүдрүүд
- E. уушигны 1-2 сегмент хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй ганц нэг юмуу олон тооны сүүдэр илрэх

/163./ Анхдагч халдварын улмаас сүрьеэгийн савханцар уушигны цулцанд нэвтэрч орох үед хамгаалах урвал хэрхэн явагдах вэ?

- A. бүрэн гүйцэт фагоцитоз явагдаж сүрьеэгийн нянг устгана
- B. бүрэн бус фагоцитоз явагдан, сүрьеэгийн нян залгигдаад эс дотор үржиж фагоцит эсийг устахад чөлөөлөгдөнө.
- C. аль аль нь явагдана

/164./ ОЭДС-гийн эмчилгээг доод тал нь хэдэн мэдрэг эмээр эхлэх вэ?

- A. 4
- B. 5
- C. 3

/165./ Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг бүртгэх маягтыг нэрлэнэ үү?

- A. ТВ 05
- B. ТВ 15
- C. ТВ 01

/166./ БЦЖ вакцин нь хүүхдийг ямар хэлбэрийн сүрьеэгээс найдвартай хамгаалдаг вэ?

- A. сүрьеэгийн хүнд хэлбэрүүд /тархмал сүрьеэ, сүрьеэгийн менингит/
- B. анхдагч сүрьеэгийн хэлбэр
- C. бүх хэлбэрийн сүрьеэ

/167./ Өрхийн эмч хариуцсан өрхөөр явж цэр цуглуулан шинжилж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг ашигласан бэ?

- A. идэвхитэй
- B. идэвхигүй
- C. хагас идэвхитэй

/168./ Дугуй нэвчдэст сүрьеэгийн үед илрэх клиник шинжийн онцлогийг бичнэ үү?

- A. шинж тэмдэг илрэхгүй
- B. шинж тэмдэг бүдэг илэрсэн аажим явцтай
- C. шинж тэмдэг тод илэрсэн, хурц явцтай
- D. дээрхи бүгд

/169./ Уушигны голомтот өөрчлөлт идэвхитэй байгаа тохиолдолд тодрол нь ямар байх вэ?

- A. бага буюу сул
- B. янз бүрийн
- C. өндөр
- D. дунд зэрэг
- E. аль нь ч байж болно.

/170./ Бөөрний дутагдлыг хүндрүүлэх нөлөөтэй эмийг нэрлэнэ үү?

- A. Этионамид
- B. Циклосерин
- C. Канамицин

- D. Офлаксоцин
- E. Пиразинамид

/171./ БЦЖ вакциныг найруулаад хэдэн цагийн дотор хэрэглэх ёстой вэ?

- A. 30 мин
- B. 1 цаг
- C. 2 цаг
- D. 5 цаг
- E. 24 цаг

/172./ Анхдагч сүрьеэгийн үед захын тунгалагийн булчирхай ямар бүлэг нь ихэвчлэн гэмтдэг вэ?

- A. эгэмний дээд
- B. суганы
- C. хүзүүний, дагзны, эрүүний доорхи
- D. цавьны
- E. эгэмний доод

/173./ ОЭДС-гийн эмчилгээний үр дүн ОУ-ын хэмжээнд дунджаар хэдэн хувь бэ?

- A. 50 %
- B. 80%
- C. 90%

/174./ Өвчтөн М .21 настай, цээжний эгц ба хажуу рентген зурагт бөрүүн уушигны эмжээгээр жижгэрсэн дунд дэлбэнд нэгэн жигд сүүдэржилттэй, энэ уушигны угийн зураглал бүдгэрсэн, бүтэц алдагдсан, баруун талын өрц өргөгдөн 5-р хавирганы түвшинд байрласан гэсэн өөрчлөлтүүд илэрчээ. Онош тодруулахын тулд ямар ямар нэмэлт шинжилгээ хийх шаардлагатай вэ?

- A. цэрэнд хорт хавдрын эс хайх
- B. цэрэнд хүчилд тэсвэртэй нян хайх

- C. гуурсан хоолой дурандах
- D. антибиотикоор туршиж эмчлэх
- E. А ба В хариултуудыг сонгож хийх

/175./ Сүрьеэгийн өвчлөл болон тархалтыг бууруулахад нөлөөлдөг гол урьдчилан сэргийлэх аргыг сонгоно уу?

- A. сүрьеэтэй өвчтөнг тусгаарлах
- B. БЦЖ вакцин хийх
- C. химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх
- D. түрхэц эерэг тохиолдлыг эрт илрүүлж эмчлэх
- E. урьдчиан сэргийлэх үзлэгийг тогтмол хийх

/176./ Сүрьеэгийн бронхаденитыг ялган оношлох бвчнүүдийг нэрлэнэ үү?

1. лимфийн хавдарууд/ лимфогрануломатоз, лимфосаркома, лимфолейкоз/
2. төвийн гаралтай хорт хавдар
3. өвөрмөц бус лимфаденопати/ корь,коклюш, вирусын халдварт өвчин/
4. улаан хоолойн хавдар
5. уушигны хурц хатгаа

/177./ Уушигны халдвартай сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 настай хүүхдэд Мантугийн сорил тавиад 72 цагийн дараа хэмжихэд 6 мм гүвдрүү жижиг цэврүүний хамт үүссэн бол эн урвалыг юу гэж дүгнэх вэ? Цаашид таны авах арга хэмжээ:

1. мантугийн сорилын хэт өндөр эерэг урвал
2. мантугийн сорилын эерэг урвал
3. гэрлийн шинжилгээнд өөрчлөлтгүй бол химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.
4. халдварлагдсан гэж үзээд цаашид ажиглана
5. гэрлийн шинжилгээ хийнэ

/178./ Туберкулины сорил тавих зорилгыг нэрлэнэ үү?

1. БЦЖ вакцины давтан тунг хийлгэх хүүхдийг сонгон авах
2. сүрьеэгийн халдварын жилийн эгзэгийг тодорхойлох
3. хүүхдэд сүрьеэгийн халдварыг эрт илрүүлэх
4. сүрьеэтэй өвчтөнд хяналт хийх
5. бүх хэлбэрийн сүрьеэг оношлох

/179./ Голомтот сүрьеэгийн төгсгөл:

1. бүрэн шимэгдэнэ
2. хатуурч шохойжсон голомт үүсэх
3. хөндий үүсэх
4. даамжирч нэвчдэс үүсэх
5. тархмал сүрьеэ үүсэх

/180./ БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлалтай хүүхдийн туберкулины сорилын урвалын онцлогийг тоочно уу?

1. үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр буурна.
2. улайлт , гүвдрүүний хэмжээ ойролцоо байна
3. эерэг урвалтай буюу 12 мм хүртэл хэмжээтэй гүвдрүү үүснэ
4. хэт эерэг урвалтай буюу 12 мм –ээс дээш хэмжээтэй гүвдрүү үүснэ.
5. үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр ихсэнэ

/181./ Уушигны гэрлийн шинжилгээнд тархмал сүүдрийн хам шинж ямар өючнүүдийн үед илэрч болох вэ?

1. уушигны милиар сүрьеэ
2. уушиг тоосжих өвчин
3. хорт хавдарын метастаз
4. голомтот хатгалгаа
5. уушигны буглаа

/182./ Голомтот сүрьеэгийн үед ихэнхдээ:

1. цээжээр өвдөх, цэртэй ханиана
2. цустай цэр гарна
3. амьсгаадна.
4. онцын зовиур илрэхгүй
5. өндөр халуурч , хөлөрнө.

/183./ Уушигны архаг тархмал сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх голомтот өөрчлөлтийн онцлогийг тоочно уу?

1. янз бүрийн хэмжээтэй болон тодролтой, жигд бус тархсан олон голомтууд
2. уушигны эдсоривжиж, доод хэсэгт тэлэлтийн шинжтэй
3. уушгинд нимгэн ханатай “тамгалсан” хөндий үүссэн
4. уушгинд бүтэц эвдрэлт өөрчлөлтгүй
5. нэгэн ижил жижиг хэмжээтэй , жигд тархсан олон голомтууд

/184./ Сүрьеэгээс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн аргуудыг нэрлэнэ үү?

1. сүрьеэтэй өвчтөнг тусгаарлах
2. БЦЖ вакцин
3. хувийн ариун цэвэр сахих
4. химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
5. урьдчилан сэргийлэх үзлэг

/185./ Хүүхдийн сүрьеэг оношлоход хэрэглэдэг гол шинжилгээнүүд нь:

1. цэрний шинжилгээ
2. гэрлийн шинжилгээ
3. томографийн шинжилгээ
4. туберкулины сорил
5. цусны шинжилгээ

/186./ Голомтот сүрьеэгийн хүндрэлүүдийг нэрлэнэ үү?

1. нэвчдэст сүрьеэ
2. плеврит
3. хөндийт сүрьеэ
4. туберкулёма

5. уушигны эд соривжих
- /187./ Уушигны хурц милиар сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тоочно уу?
1. зөвхөн нэг талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан
 2. хоёр талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан
 3. жижиг болон дунд зэргийн хэмжээтэй голомтууд тодорхойлогдоно
 4. олон тооны шар будаа шиг жижиг голомтууд тодорхойлогдоно
 5. уушгинд “тамгалсан” хөндий үүссэн байна
- /188./ Цээжний хөндийн тунгалагийн булчирхайн сүрьеэгийн клиник-рентгены хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. бага хэлбэр
 2. хавдар маягийн хэлбэр
 3. нэвчдэст хэлбэр
 4. хүндрэлтэй хэлбэр
 5. шинж тэмдэггүй хэлбэр
- /189./ Уушигны хоёрдогч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?
1. насанд хүрэгсэд ихэнхдээ өвчилнө
 2. задрах хандлага өндөртэй эмчилгээ заавал шаардлагатай
 3. цусаар тархах хандлагагүй, голдуу уушгийг гэмтээнэ
 3. цусаар тархах хандлагагүй, голдуу уушгийг гэмтээнэ
 4. бактеремия заавал болно
 5. цусаар тархах хандлага өндөртэй
- /190./ Туберкулины сорилын хариуг бууруулдаг шалтгаануудыг тоочно уу?
1. жирэмслэлт
 2. витамин дутагдал
 3. халдварт өвчин
 4. сүрьеэгээр өвчлөх
 5. харшил
- /191./ Уушигний гэрлийн шинжилгээнд ямар өвчнүүдийн үед цагираг сүүдрийн хам шинж илрэх вэ?
1. гуурсан хоолойн гаралтай киста
 2. хавдрын задрал
 3. хөндийт сүрьеэ
 4. уушигний хатгалгаа
 5. туберкулема
- /192./ Урьд жилүүдэд туберкулины сорилд сөрөг урвалтай байсан 5 настай хүүхдэд 2 ТЕ ППД-Л Мантугийн сорил тавьж 72 цагийн дараа хэмжихэд хөхөлбөр улаан өнгөтэй 18 мм хэмжээтэй гүвдрүү үүссэн бол урвалыг юу гэж дүгнэх вэ?
1. хэт өндөр эерэг урвал
 2. вираж илэрсэн
 3. халдварлагдсаны дараахь урвал
 4. БЦЖ вакцины дараахь урвал
 5. эерэг урвал
- /193./ ОЭДС-гийн тандалтыг хүн амын ямар бүлгүүдэд хийх вэ?
1. Эмчилгээ тасалсаны дараахь
 2. Сүрьеэгийн 2-р бүлгийн эхэнд
 3. Сүрьеэгийн 1-р бүлгийн үр дүнгүй үед
 4. Сүрьеэгийн 1-р бүлгийн эхэнд
 5. Сүрьеэгийн 1-р бүлгийн 2 сарын түрхэц эерэг тохиолдолд
- /194./ Сүрьеэгийн анхдагч бүрдэлийн хүндрэл нь :
1. голомтот сүрьеэ үүсэх
 2. анхдагч хөндий үүсэх
 3. туберкулёма үүсэх
 4. казеоз хатгалгаа хэлбэрт шилжих
 5. бусад эрхтний сүрьеэ үүсэх

/195./ Голомтот сүрьеэтэй өвчтний бодит үзлэгт ямар өөрчлөлтүүд илрэх вэ?

1. цээжний хэнхэрцэг өөрчлөлтгүй
2. тогшилтоор болон чагналтаар онц өөрчлөлтгүй
3. цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно
3. цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно.
4. цээжний хэнхэрцэгийн нэг тал амьсгалд хоцорч оролцоно
5. цээжний хэнхэрцэг торх хэлбэртэй болсон байна.